

ОЮУНЫ ҮЙЛ ЯВДЛУУД

Mental events by Donald Davidson

Орчуулсан: Э.Баасандорж, магистр

МУИС, Философи, шаашин судлалын тэнхим

Хүртэж мэдрэх, санах, шийдэх, үйлдэх гэх мэт оюуны (mental) үйл явдлууд физикийн онолын хууль цаазын торонд баригддаггүй. Энэ баримтыг оюуны үйл явдлуудын физик ертөнцөд нөлөөлөх шалтгаацлын үүрэгтэй хэрхэн эвсүүлэх вэ? Шалтгаацлын детерминизм нь мөнөөх хууль цаазын торонд баригддаг, харин эрх чөлөө байхын тулд уг торноос зугтах арга зам шаардлагатай хэмээн үзвэл эрх чөлөөг шалтгаацлын детерминизмтэй эвсүүлэх явдал бол дээрх асуудлын нэг өвөрмөц тохиолдол мөн. Гэхдээ чөлөөт үйлдэл детерминизмтэй ердөөс зөрчилдөхгүй байна хэмээх зөв задлан шинжилгээнд итгэж буй хүнд хүртэл цаана нь буй илүү өргөн хүрээний асуудал амьд хэвээр үлдэж болно. Автономи (эрх чөлөө, өөртөө-засаглах) нь детерминизмтэй мөргөлдөж болно, үгүй ч байж болно; хэв бус тохиолдол (anomaly буюу хуульд үл хамаарах тохиолдол) бол өөр асуудал шиг харагдана.

Би оюуны үйл явдлууд дахь шалтгаацлын хараат байдал хийгээд хэв бус чанар болбоос хоёул үгүйсгэх аргагүй баримт мөн гэх үзэлд тулгуурлаж эхлэлээ тавина. Иймд би илэрхий тулгарч буй хүндрэлүүдийн өмнө үүнийгээ хамгаалж тайлбарлахыг зорилгоо болгов. Би Кантын дараах үгд элэгсэг хандаж байгаа,

Хамгийн нийтлэг сэтгэхүй, хамгийн гярхай философи ч эрх чөлөөг үгүй хийх үндэслэл дэвшүүлж дөнгөхгүй. Иймд философи нь эрх чөлөө хийгээд натурал зайлиггүй чанарын дунд ямар нэг үнэн зөрчил байхгүй хэмээн үзэх ёстой, учир нь философи байгалийн тухай санааг орхиж

болохгүй шиг, эрх чөлөөний тухай санааг ч орхиж үл болно. Эрх чөлөө байх боломж хэрхэн гарч ирж буйг хэзээ ч ухан ойлгож чадахгүй байлаа гэхэд, ядаж л энэ илэрхий зөрчлийг итгэл төрүүлэхүйц байдлаар үгүй хийх ёстой. Яагаад гэвэл эрх чөлөөний талаарх бодол өөртэйгөө эсвэл байгальтай зөрчилддөг . . . энэ нь натурал зайлиггүй чанартай өрсөлдөөд, бууж өгөх учиртай болдог.¹

Хүний үйлдлүүдийг оюуны үйл явдлуудад ерөнхийлөөд, эрх чөлөөг хэв бус тохиолдлоор орлуулбал миний авч үзэж буй асуудлын дүрслэл болно. Бас Кантын үзсэнээр эрх чөлөө бол хэв бус байдлыг дагуулдаг учраас дээрх зүйлсийн холбоо илүү ойр болох нь мэдээж хэрэг юм.

Харин одоо миний авч үзээд, эцэст нь бутаргах гэж буй оюуны үйл явдлуудтай холбоотой 'илэрхий зөрчилдөөн'-ий тухайд илүү анхааралтай авч үзэх гээд оролдоё. Үүнийг гурван зарчимд тулгуурлаж байна хэмээн үзэж болох юм.

Эхний зарчим нь ядаж зарим оюуны үйл явдал физик үйл явдлуудтай шалтгаан үр дагаварын харилцан хамааралд оршдог хэмээн батлан хэлдэг. (Үүнийг Шалтгаацал бүхий Харилцан Хамаарлын Зарчим гэж болох юм.) Иймд, жишээ нь, хэн нэг хүн Бисмаркыг живүүлсэн гэвэл хүртэж мэдрэх, тэмдэглэх, тооцоолох, шүүн шийдэх, шийдвэр гаргах, санаж зорин үйлдэх, итгэл үнэмшил өөрчлөгдөх гэх мэт төрөл бүрийн оюуны үйл явдлууд Бисмарк живсэн явдлын шалтгаан болсон байж таарна. Тодруулбал, хэн нэг хүн Бисмаркыг живүүлсэн гэдэг нь тухайн хүн тодорхой төрлийн оюуны

¹ *Fundamental Principles of the Metaphysics of Morals*, 75-76.

үйл явдлуудаас шалтгаалах байдлаар биеэ хөдөлгөсөн, харин тэр хөдөлгөөн нь Бисмаркыг живүүлж таарсан хэмээн мэтгэнэ.² Хүртэхүй бол шалтгаалал физик зүйлээс оюуны зүйл рүү хэрхэн дамжиж болдгийг зураглана: хүн нэг усан онгоц ирж байгааг хүртэж мэдэрсэн бол ирж яваа усан онгоц түүнийг усан онгоц ирж байна хэмээн итгэх шалтгаан болсон байж таарна. (Эдгээрийг шалтгаалалын харилцан хамаарал хэмээн хүлээн зөвшөөрөх явдалд юу ч тулгуурлахгүй.)

Хүртэхүй хийгээд үйлдэл нь оюуны болон физик үйл явдлууд хэрхэн шалтгаалалын харилцан хамааралд байгааг харуулах хамгийн тодорхой тохиолдлууд мөн хэдий ч эцсийн дүндээ бүх оюуны үйл явдлууд, магадгүй бусад оюуны үйл явдлуудтай үүсгэх шалтгаалалын харилцаагаар дамжаад, физик үйл явдлуудтай шалтгаалалын харьцаанд байдаг. Гэхдээ шалтгаан эсвэл үр дагавар нь физик үйл явдал байдаггүй тийм оюуны үйл явдлууд байдаг бол дээрх үндэслэл тэдгээрийг хөндөхгүй.

Хоёр дахь нь аваас шалтгаалал байгаа бол хууль байх учиртай гэх зарчим юм: шалтгаан ба үр дагавар болохын хувьд хоорондоо холбоотой үйл явдлууд чанд детерминист хуулиуд дор байдаг. (Үүнийг Шалтгаалалын Хууль Цаазат Шинж хэмээн нэрлэж болно.) Энэ зарчмыг өмнөхтэй ижлээр угтуул санаа (presupposition) болгож хэрэглэх ч гэлээ тайлал болгож нэг зүйл хэлэх учиртай.³

Гурав дахь нь урьдчилан таамаглаж, тайлбарлаж болох оюуны үйл явдлуудад тулгуурласан чанд детерминист хууль байхгүй гэх зарчим болно.

Дээрх үзлүүд эсвэл зарчмуудыг хүлээн зөвшөөрөх гэдэг ч, эдгээрийг нэг нэгтэйгээ

зөрчилтэй хэмээн боддог хүмүүст төрдөг парадоксыг би хэлэлцэн үзэх гэж байгаа юм. Зөрчилт байдал нь мэдээж хэрэг өөр нөхцөлүүдийг нэмээгүй л бол формал шинжтэй байна. Юутай ч эхний хоёр зарчим буюу шалтгаалал бүхий харилцан хамаарлын зарчим, шалтгаалалын хууль цаазат шинжийн зарчим хоёр хамтдаа оюуны үйл явдлуудын ядаж зарчмыг нь хуульд тулгуурлаад урьдчилан таамаглаж бас тайлбарлаж болно гэх санааг илтгэж байхад оюуны хэв бус тохиолдлын зарчим үүнийг үгүйсгэдэг гэж учирлахад гайхах зүйл үгүй. Энэ гурван зарчим зөрчил өөд хөтөлнө хэмээн олон философич үндэслэгээ дэвшүүлж бас дэвшүүлэлгүйгээр шууд тийн үзжээ. Гэхдээ дээрх гурван зарчмыг би үнэн гэж харж байгаа. Иймд би зөрчилтэй гэж харагдах байдлыг нь үргээх тайлбар хийх ёстой болж байна; мөн чанараараа Кантын залгамж болсон тайлбар.

Өгүүллийн үлдсэн хэсгийг гурав хуваасан. Эхнийхэд нь оюуны хийгээд физик шинжүүдийн адилслын тухай онолын гурван зарчмыг хооронд нь хэрхэн эвсүүлж болох талаар харуулдаг нэг хувилбарыг дүрсэлнэ. Хоёр дахь хэсэгт сэтгэц-физикийн чанд хууль байх боломжгүй хэмээн үндэслэх болно; энэ нь оюуны хэв бус тохиолдлын зарчим гэдгээс илүүтэй утга учиртай үзлээс гарч байгаа юм. Сүүлийн хэсэгт сэтгэц-физикийн хууль байх боломжгүй гэдэгт бас нөгөө хоёр зарчимд тулгуурлаад адилслын онолын нэг хувилбарыг, өөрөөр хэлбэл ядаж зарим оюуны үйл явдлыг физик үйл явдлуудтай адил гэх онолыг үнэн хэмээн үзэж болохыг харуулахаар оролдсон. Адилслын онолын 'нуталгаа' хамгийн сайндаа нөхцөлт шинжтэй (conditional) байна гэдэг нь тодорхой, учир нь үүнд буй хоёр логик нөхцөл (premise) нь дэмжлэггүй бас гуравдахад нь зориулсан

2 Эдгээрийг тус номын 1 ба 3-р эсээнд хамгаалсан.

3 7-р эсээнд би энд ярьж буй шалтгаалалын талаарх үзлийг дэлгэрэнгүй авч үзсэн. Хуулиуд детерминист шинжтэй байна гэдэг болзол нь сэтгэхүйн шаардаж байгаагаас илүү хатуу бөгөөд үүнийг зөвлөх болно.

үндэслэл шийдвэрлэх үүргийг гүйцэтгэж дөнгөхөөргүй санагдаж болно. Гэхдээ логик нөхцөлүүдийн үнэнд үнэмшээгүй нэгэн ч тэдгээрийг хэрхэн эвсэж болохыг бас эдгээр нь оюуныг адилсуулах онолын нэг хувилбарыг бий болгох тухайд сонирхож болно. Эцэст нь, хэрэв үндэслэл маань сайн бол адилслын онолын нөхөд бас дайснууд болсон хүмүүсийн дунд нийтлэг байдаг үзлийг буюу сэтгэц-физикийн хуулийг нээн илрүүлсний үндсэнд л адилслын онолуудын түшцийг гарган авч болно гэх үзлийг нойрсуулах учиртай.

I

Оюуны хийгээд физикийн гэдгийн талаарх, дотоод зөрчил агуулдаггүй бас мөнөөх гурван зарчмыг дагуулдаг үзлийг дүрсэлж үзүүлснээр дээрх гурван зарчим хоорондоо нийцэлтэй гэдгийг харуулна. Тийм үзлийн дагуу бол оюуны үйл явдлууд физик үйл явдлуудтай адилсдаг. Үйл явдлуудыг галт уулын тухайлсан нэг дэлбэрэлт, хүний (эхний) төрөлт эсвэл үхэл, 1968 онд болсон Дэлхийн аваргын Цуврал Тэмцээн эсвэл ‘Бэлэн болсон үедээ галлаж болно, Гридлей’ гэх мэт түүхэн үгстэй ижилхэн давтах аргагүй, тодорхой хугацаатай нэгж юмс хэмээн үздэг. Нэгж үйл явдлуудын талаарх адилслын бодомжуудыг бид хялбархан хүрээлж болно; жишээ гэвэл (үнэн эсвэл худал) дараахыг дурдаж болно:

Скоттын үхэл = Вейверлигийн зохиогчийн үхэл;

Хунтайж Фердинандын захиалгат аллага = Дэлхийн нэгдүгээр дайныг эхлүүлсэн үйл явдал;

Нийтийн тооллын 79 онд болсон Везуви галт уулын дэлбэрэлт = Помпей хот сүйдсэн шалтгаан.

Үйл явц, төлөв, шинж зэрэг нь нэгж үйл явдлуудаас өөр байвал энд авч үзэж буй онол тэдгээрийн тухайд юм хэлдэггүй.

Үйл явдлыг оюуны эсвэл физик гэж хэлэх нь юу гэсэн үг вэ? Цэвэр физик үгсийн сангаар дүрслэгдэж байвал физик үйл явдал, оюуны нэр томъёогоор дүрслэгдэж байвал оюуны гэх нь нийтлэг байх нэгэн хариулт юм. Гэхдээ үүнийг ямар нэг физик предикат аливаа үйл явдалд үнэн болж байвал тэр нь физик үйл явдал болно гэх санааг илтгэж байна хэмээн үзвэл дараах хүндрэл гарч ирнэ. ‘Ноозагийн толгойд *x* тохиосон’ гэдгийг физик үгсийн санд хамаардаг гэж үзье, тэгвэл ‘Ноозагийн толгойд *x* тохиогоогүй’ гэдэг предикат ч бас физик үгийн санд хамаарах ёстой. Гэхдээ ‘Ноозагийн толгойд *x* тохиосон эсвэл тохиогоогүй’ гэх предикат бүх үйл явдлын тухайд, оюуны эсвэл физик эсэхээс үл хамааран үнэн байх болно.⁴ Бид бүх үйл явдалд тавтологи байдлаар үнэн байх предикатуудыг хасаж болох ч үйл явдал бүрийг ‘Ноозагийн толгойд *x* тохиосон’ эсвэл ‘Ноозагийн толгойд *x* тохиогоогүй’ гэдэг предикатаар үнэнээр дүрсэлж болох учраас тэгэх нь ямар ч тусгүй. Өөр арга барил хэрэгтэй болж байна.⁵

Итгэх, санаж зорих, хүсэж эрмэлзэх, найдах, мэдэх, хүртэж мэдрэх, анзаарах, санах гэх мэт хэллэгэн хандлагыг (propositional attitudes) илэрхийлдэг үйл үгсийг оюуныхэмээж болох юм. Тийм үйлүгс заримдаа хүнийг заасан өгүүлэгдэхүүнтэй өгүүлбэрт ордог бас орлуулгын хэвийн дүрмүүдийг эвдэх тусагдахуун гишүүн өгүүлбэрээр бүрэн гүйцэд болдог гэдгээрээ онцлог. Би энэ үйл үгсийг бүхэлдээ (fully extensional) хам сэдвүүдэд (‘Тэр хүн Парисыг мэднэ,’ ‘Тэр хүн сарыг хүртэн мэдэрдэг’ зэрэг нь үүний жишээ юм) гарч

⁴ Энэ оюуны үйл явдлуудыг байрлалтай хэмээн ухварлагдахуйцаар хэлж болно гэх үзлээс хамаарна; гэхдээ энэ бол адилслын онол үнэн үед үнэн байх үзэл бөгөөд би энэ онолыг батлах гэж биш харин томъёолохыг оролдож байгаа.

⁵ Ли Бөви энэ хүндрэлийг онцолж, тус хүргэсэн.

ирэх үед нь хамаатуулж үзэхийг ч, араасаа тусагдахуун гишүүн өгүүлбэр дагуулаагүй үед нь хасахыг ч хүсэхгүй байгаа учраас дээрх нь яв цав шалгуур биш. Энд хэрэгтэй оюуны үйл үгсийн (mental verbs) ангийг илэрхий тэлсэн-бус хам сэдвийг бий болгох үед хэрэглэдэг сэтгэл зүйн үйл үгс хэмээн өөрөөр тодорхойлж болох юм.

Хэрэв 'M'-ийг орлох илэрхийлэл нь ядаж нэг оюуны үйл үгийг гол хэсэгтээ агуулж байгаа бол энэ нь 'M гэдэг үйл явдал' гэх хэлбэр бүхий дүрслэл эсвэл 'x үйл явдал бол M' гэх хэлбэр бүхий нээлттэй өгүүлбэрийг оюуны дүрслэл (mental description) эсвэл оюуны нээлттэй өгүүлбэр гэх зайлшгүй бөгөөд хүрэлцээтэй нөхцөл болно гэе. (Гол хэсэгтээ гэдэг нь, тухайн дүрслэл эсвэл нээлттэй өгүүлбэр нэг оюуны үйл үг агуулсан эсвэл огтоос агуулаагүйтэй логикийн хувьд тэнцүү байх тийм тохиолдлуудыг үл тооцох байдлаар.) Ингээд бид аливаа үйл явдалд оюуны дүрслэл байгаа үед л, эсвэл (дүрслэлийн оператор нь примитив биш гээд) зөвхөн тухайн үйл явдлын хувьд л үнэн байх оюуны нээлттэй өгүүлбэр байгаа үед тэр үйл явдлыг оюуны гэж хэлж болох юм. Физик үйл явдлууд бол гол хэсэгтээ зөвхөн физик үгсийг агуулдаг дүрслэлүүд эсвэл нээлттэй өгүүлбэрүүдийн шилэн сонгодог тийм үйл явдлууд мөн. Физик үгсийн санг тодорхойлох нь өмнөх шиг чухал биш. Учир нь энэ үгсийн санг оюуныхтай харьцуулахад, зүйрлүүлж хэлбэл, энэ нь аливаа дүрслэлийг оюуны эсвэл физик эсэхийг тогтооход, рецессив шинжтэй байдаг. (Хойшоо физик үгсийн сангийн уг чанарын тухайд зарим санал сэтгэгдэл гарна. Гэхдээ тэдгээр нь шалгуур болж дөнгөхгүй.)

Оюуны гэдгийн тухайд санал болгож буй тест дээр оюуны гэдгийг ялгах шинж нь хувийн, субъектив эсвэл материаллаг бус шинж биш харин Брентаногийн интенционал чанар хэмээсэн зүйлийг үзүүлдэг. Тэгэхээр интенционал үйлдлүүд

нь бодол, найдвар, харуусалтай (эсвэл эдгээрт уяатай үйл явдлуудад) хамтаар оюуны гэх талбарт багтаж орох нь илэрхий юм. Эргэлзээтэй харагдаж болох зүйл гэвэл шалгуур нь оюуны гэдгийн талаарх, ихэнхдээ парадигматик хэмээн тооцогддог, тэр үйл явдлуудыг агуулах эсэх тухай асуудал байна. Жишээ нь, өвдөлт мэдрэх эсвэл ой тоонд үлдсэн дүр зураг (after-image) зэрэг нь оюуны гэдэгт хамаарах нь мэдээжийн зүйл гэж үү? Тийм үйл явдлуудыг мэдэгддэг өгүүлбэрүүд үл-тэлсэн байдлын толбоор сэвтээгүй мэт байдаг. Түүхий мэдрэмж (raw feels), сэрэл мэдрэхүйн өгөгдөл (sense data) хийгээд тайллаар ороогүй (uninterpreted) бусад сэрэл мэдрэмжүүд хэрэв байдаг бол дээрхтэй мөн ижил байх учиртай.

Гэхдээ уг шалгуур өвдөлт мэдрэх, ой тоонд үлдсэн дүр зураг зэргээр зогсохгүй, өөр хамаагүй олон зүйлсийг бүрхэж байгаа. Хүн интуитив байдлаар физик шинжтэй гэж хэлэх ямар нэг үйл явдлыг авч үзье. Жишээ нь, алс тэртээд буй хоёр одны мөргөлдөөн байж болно. Энэ бас бусад мөргөлдөөний тухайд үнэн байх боловч чухам энэ мөргөлдөөн тохиож байх тэр мөчид зөвхөн уг мөргөлдөөний тухайд л үнэн байх 'Px' гэх цэвэр физик предикат байх ёстой. Энэ тухайлсан нэг мөч Жонес ширээн дээр нь үзэг өнхөрч эхлэхийг анзаарсан тэр цагтай давхцаж болно. Алсад буй оддын мөргөлдөөн тэгэхээр мөнөөх x үйл явдлын хувьд Px байхуйц бас Жонес ширээн дээр нь үзэг өнхөрч эхлэхийг анзаарахтай нэгэн зэрэг тохиосон байна. Тэгвэл энэ мөргөлдөөнийг оюуны дүрслэл шилэн тогтоож байгаа бөгөөд үүнийг оюуны үйл явдал хэмээн тооцох ёстой боллоо.

Ийм стратегиар бүх л үйл явдлыг оюуны хэмээн харуулж ч болох; бид оюуны гэх интуитив ойлголтыг яах аргагүй барьж авч чадсангүй. Энэ асуудлыг засахаар оролдох нь сургамжтай байх хэдий ч одоогийн зорилгод маань зайлшгүй шаардлагатай биш. Тохиолдлын оруулгууд бүх оюуны

үйл явдал физик үйл явдалтай адил гэх таамаглалыг л хүчирхэгжүүлж болох учраас бид Спинозагийн хэтрүүлгийг зөвшөөрч болох юм. *Bona fide* оюуны үйл явдлуудыг оруулж чадахгүй байх явдал асуудал болно, харин энэ тухайд аюул байхгүй шиг харагдаж байна.

Би оюуны ба физикийн хоёрыг холбосон чанд хууль байх боломжтой гэдгийг үгүйсгэдэг нэг төрлийн адилслын онолыг дүрсэлж бас үүний тухайд үндэслэл дэвшүүлмээр байна. Ийм онол байх боломжийг адилслын онолууд руу дайрч бас тэдгээрийг өмгөөлдөг нийтлэг арга замаар хялбархан бүрхэгдүүлнэ. Жишээ нь, Чарлес Тейлор оюуны гэж дүрслэгдэх үйл явдлуудыг физик хэмээн дүрслэгдэх үйл явдлуудтай холбосон хамаарал эсвэл хуулийг батлан гаргаж болно гэх үзэл бол тийм онолуудыг хүлээн зөвшөөрөх цор ганц 'суурь' мөн гэдэг дээр адилслын онолын гол баатруудтай санал нийлдэг. Тэр ийн хэлсэн бий: 'Яагаад гэдгийг нь амархан харж болно: жишээ нь өгөгдсөн оюуны үйл явдлыг өгөгдсөн тархины үйл явц тогтмол дагадаг биш л бол энэ хоёрын дундах ерөнхий адилслын тухайд ч авч хэлэлцэх суурь үгүй.'⁶ Тейлор цааш (минийхээр бол зөвөөр) хамаарал бүхий хуулиудгүйгээр адилсал байж болно гэдгийг зөвшөөрдөг, гэхдээ, одоо бол би дөнгөж сая ишилсэн бодомжид буй эргэлзээ өөд урилгыг анзаарахыг л сонирхож байна. Энд буй 'өгөгдсөн оюуны үйл явдал' гэдэг нь юуг хэлж байж болох вэ? Тухайлсан нэг өнгөрсөн үйл явдал биш, учир нь аливаа нэгж үйл явдлыг өөр нэг нь 'тогтмол дагадаг' гэж ярих нь утгагүй. Тейлор өгөгдсөн төрлийн үйл явдлуудын

тухайд бодож байгаа нь баталгаатай. Гэхдээ ийм төрлийн үйл явдлуудын дунд л адилсал байдаг юм бол адилслын онол хамаарал бүхий хуулиудад тулгуурлаж байна.

Хуулиудыг адилслын онолын бодомжууд болгож босгох мөн ижил хандлага дараах нийтлэг тайлбаруудаас олдоно:

*Би сэрэл мэдрэмж бол тархины үйл явц эсвэл аянга бол цахилгааны цэнэг буух явдал гэж хэлэхдээ, 'бол' гэдгийг чанд адилсал гэх үүднээс хэрэглэж байгаа . . . энд аяндын гялбаа, цахилгааны цэнэг гэсэн хоёр тусдаа зүйл байгаа хэрэг биш. Аяндын гялбаа буюу шинжлэх ухаанд йонжсон усны молекул бүхий үүлнээс газарт буух цахилгааны цэнэг хэмээн дүрсэлдэг нэг л зүйл бий.*⁷

Энэ ишлэлийн сүүлийн өгүүлбэрийг аяндын гялбаа тус бүрд адилсах йонжсон усны молекул бүхий үүлнээс газарт буух цахилгаан цэнэг оршиж байгаа гэж хэлж байгаа мэтээр ойлгож болох юм. Энд нэгж үйл явдлуудын талаарх цэгц шулуун онтологи байна, бас бид адилслын утгат чанарыг яг л гаргаж болж байна. Бас хамаарал бүхий хуульгүйгээр хэрхэн адилсал байж болохыг харж болж байна. Гэхдээ дурын адилсал харилцан хамаарал бүхий ямар нэг хууль байгааг илтгэх тийм байдлаар нарийвчилсан хувьшлын нөхцөлүүд бүхий үйл явдлуудын онтологи байх боломж бий. Жишээ нь, $a = b$, бас F байх шинж = G байх шинж гэдэг нь Fa , Gb хоёр нь 'нэг ижил үйл явдлыг дүрсэлж эсвэл заадаг' гэдгийн зайлшгүй бөгөөд хүрэлцээтэй нөхцөл мөн гэх санааг дэвшүүлжээ. Тэгэхээр шинжүүдийн

6 Charles Taylor, 'Mind-Body Identity, a Side Issue?', 202.

7 J. J. C. Smart, 'Sensations and Brain Processes'. Энд ишлэлсэн хэсэг *The Philosophy of Mind*, ed. V. C. Chappell (Englewood Cliffs, N.J., 1962)-ийн шинэчилсэн хэвлэлийн 163-5-р талд бий. Өөр нэг жишээг David K. Lewis, 'An Argument for the Identity Theory'-аас харна уу. Лювис үйл явдлуудыг универсалууд (р. 17, зүүлт 1 ба 2) болохынх нь хувьд авч үзэх үед мөнөөх үзэл тодорхой харагдана. Би Смарт, Лювис нарыг эндүүрсэн гэж хэлээгүй. Адилслын онолыг балан хэлэх арга зам нь тухайлсан үйл явдлууд ба миний томъёоллын тулгуур болж буй тэр үйл явдлууд хоорондын заагийг бүдэгдүүлж байна л гэж хэлсэн.

адилслаас (х) ($Fx \leftrightarrow Gx$) урган гарч таарна.⁸ Ким дараах зүйлийг хэлсэнд гайхах зүйл үгүй:

Хэрэв өвдөлт нь тархины төлөв В-тэй адилсдаг бол, өвдөлт тохиох үед тархины төлөв В зэрэг тохиох учиртай Тэгэхээр өвдөлт хийгээд тархины төлөв В хоёрын адилсал байх зайлиггүй нөхцөл нь 'өвдөх' хийгээд 'В тархины төлөвт байх' хоёр ижил багтаамжтай байх явдал мөн Адилслыг нь баталж эсвэл няцаагаад холбогдох хамаарлыг нь тэгэхгүй байх ойлгож болмоор тийм ажиглалт гэж үгүй.⁹

Оюуны хийгээд физик үйл явдлуудын харилцааны талаарх хуулиудын тухай баталсан мэдэгдлүүд хийгээд адилслын тухай баталсан мэдэгдлүүдийн тусгаар байдлыг онцолдог онолуудыг дөрвөн талт байдлаар ангилж үзэх нь нөхцөл байдлыг тодруулж болох юм. Нэг талаас, сэтгэц-физикийн хуулиуд оршдог гэдгийг баталдаг бас үгүйсгэдэг хүмүүс байна; нөгөө талд оюуны үйл явдлууд физик үйл явдлуудтай адилсдаг гэж хэлдэг бас түүнийг үгүйсгэдэг улс бий. Иймд онолуудыг дөрвөн төрөлд хувааж болох нь: номологийн монизм буюу хамаарал бүхий хуулиуд байдгийг, бас хамаарал бүхий үйл явдлууд нь нэг юм гэдгийг баталдаг (материалистууд энэ ангилалд хамаарна); номологийн дуализм, энэ нь параллелизм, интеракционизм, эпифеноменализм зэрэг олон хэлбэрийг хамааруулна; хэв бус тохиолдлын дуализм (anomalous dualism) буюу оюуны хийгээд физик гэдгийн дунд хамаарал бүхий хууль байх боломжгүй гэдгийг онтологийн

дуализмтай нийлүүлдэг (Cartesianism). Хамгийн сүүлд нь миний баримтлахыг хүсэж буй байр суурийг илтгэх хэв бус тохиолдлын монизм (anomalous monism) бий.¹⁰ Хэв бус тохиолдлын монизм бүх үйл явдлыг физик үйл явдал гэх баталсан мэдэгдэл дээр материализмтай санал нийлдэг ч материализмын салшгүй хэсэг хэмээн тооцогддог оюуны үзэгдлүүдэд цэвэр физик тайлбар хийж болно гэх сэдвээс татгалздаг. Хэв бус тохиолдлын монизм нь бүх үйл явдал оюуных биш байх боломжийг зөвшөөрдгийн зэрэгцээ бүх үйл явдлыг физик хэмээн зүтгэдгээрээ л онтологи өрөөсгөлийг харуулдаг. Ийм үлбэгэр монизм нь хамаарал бүхий хуулиуд эсвэл ойлголтын эдийн засгаас (conceptual economy) түшдэггүй учир 'редукционизм' хэмээх нэр томъёонд таарахгүй шиг харагдана; юутай ч энэ нь рефлексээс өөр юу ч үгүй гэх үзлийг ('Фугийн урлагийг ухаж ойлгох явдал бол нарийн цогц мэдрэлийн үйл явдлаас өөр юу ч биш юм,' болон өөр бусад) бадраагаад байдаггүй.

Миний дүрсэлж байгаа байр суурь сэтгэц физикийн хууль орших боломжийг үгүйсгэдэг ч оюуны онцлог шинжүүд болбоос тодорхой үүднээс физик онцлог шинжүүдээс хараат, эсвэл тэдгээрээс урган гарч байдаг гэх үзэлтэй нийцтэй юм. Ингэж урган гаргах шинжийг бүхий л физик талаараа төстэй боловч оюуны тодорхой талаар ялгаатай байх явдал, эсвэл тухайн нэг объект тодорхой физик талаараа өөрчлөгдөхөөс нааш оюуны талаараа өөрчлөгдөх боломжгүй байх явдал гэсэн

⁸ Jaegwon Kim, 'On the Psycho-Physical Identity Theory', 231.

⁹ Ibid., 227-8. Ричард Брант, Жайвон Ким нар Richard Brandt, Jaegwon Kim нар 'The Logic of the Identity Theory' бараг адилхан шалгуурыг санал болгожээ. Тэд үйл явдлын адилслын талаарх ойлгоцын үүднээс бол адилслын онол феномени-физикийн гэдэг нэвтэрхий (pervasive) корреллац байдаг гэдгийг илүү хүчтэй зүйлийг хэлдэг, 518. Би түүнийг нь энд авч үзэхгүй.

¹⁰ Герберт Фейл их бага хэмжээгээр хэв бус тохиолдлын монизмыг хүлээн зөвшөөрч болох байр суурь гэдгийг онцлон анхаарч байжээ. The "Mental" and the "Physical"; Sydney Shoemaker, 'Ziff's Other Minds'; David Randall Luce, 'Mind-Body Identity and Psycho-Physical Correlation'; Charles Taylor, op. cit., 207. Минийхтэй төстэй байр суурийг Томас Нейгл 'Physicalism'-даа хүлээн авсан байна. Бас П.Ф. Стосон Freedom and the Will-дээ цохон тэмдэглэжээ, 63-7.

үг хэмээн үзэж болох юм. Ийм төрлийн хараат эсвэл урган гарах байдал хууль эсвэл тодорхойлолтоор дамжуулан цомхотгогдох чанарт (reducibility) хүргэхгүй: хэрэв тэгдэг байсан бол ёс суртахууны шинжүүдийг дүрслэлийнхэд (descriptive) цомхотгож болох байсан бөгөөд ингэх аргагүй гэдэгт итгэх сайн шалтгаан бий; бас үнэнийг өгүүлбэр зүйн ерөнхий шинжийн формал тогтолцоотой цомхотгож болох байсан байж мэднэ, харин ерөнхийдөө бол ингэж болохгүйг бид мэднэ.

Энэ сүүлийн жишээ нь энд авч үзэж буй хуульгүй монизмын нэг төрөлтэй ашигтай аналог харилцаанд байна. Физик үгийн санг ямар нэг L хэлний бүх үгсийн сан гээд, үүнийг тодорхой математик, бас өөрөө өөрийнхөө өгүүлбэр зүйг зохих хэмжээнд илтгэх нөөцтэй гэж үзье. L' бол 'L-д үнэн байх' гэх үнэний предикатаар өргөжсөн L хэл бөгөөд уг предикат нь 'оюуны шинжтэй' юм. L-д (тийм болохоор бас L'-д) үнэний предикатын багтаамжид буй өгүүлбэр бүрийг тухайлах дүрслэл (definite description) эсвэл нээлттэй өгүүлбэрээр шилэн сонгох боломжтой авч L хэрэв тогтмол бол энэ нь хэчнээн нарийн цогц байсан ч L-ийн бүх бас зөвхөн үнэн өгүүлбэрүүдэд үйлчлэх ('физик' үгсийн сангийн) өгүүлбэр зүйн предикат ердөө оршихгүй. <φ> гэдгийг 'физик' предикатаар (L-ийн предикат) оруулах үед '(x) (x нь φ байна гэдэг нь x L-д үнэн байх зайлшгүй бөгөөд хүрэлцээтэй нөхцөл мөн)' гэх хоёр нөхцөлт өгүүлбэр (biconditional) бүхий хэлбэртэй 'сэтгэц-физикийн хууль' байх аргагүй. Үүнтэй ижлээр, физик үгсийн санг дангаар нь хэрэглэх замаар оюуны үйл явдал бүрийг шилэн тогтоож (pick out) болох ч ямарваа нэг цэвэр физик предикат, хэчнээн нарийн цогц байсан ч, хууль болохуйц тийм байдлаар оюуны предикаттай ижил

багтаамжтай байна гэж үгүй.

Одоо хэв бус тохиолдлын монизм эх гурван зарчмыг хэрхэн нийцүүлж байгаа нь тодорхой болж ирж байх учиртай. Шалтгаал хийгээд адилслыг яаж ч дүрсэлсэн бай хамаагүй, эдгээр нь нэгж үйл явдлуудын хоорондох харилцан хамаарал мөн. Гэхдээ хуулиуд бол хэл шинжлэлийнх юм; тэгэхээр тодорхой үйл явдлууд хуулиудын жишээ болж байж болно. Тэгэхээр бас эдгээрийг нэг эсвэл нөгөө байдлаар дүрсэлдэг шигээр хуулийн хүрээнд урьдчилан тооцоолж бас тайлбарлаж болно. Шалтгаант харилцан үйлчлэлийн зарчим тэлэлтэд буй үйл явдлуудыг (events in extension) авч үздэг бөгөөд оюуны-физик гэх заагийг хардаггүй. Оюуны юмсын хэв бус тохиолдлын зарчим нь оюуны хэмээн дүрслэгдэх үйл явдлуудыг хэрэг зоригоо болгодог, учир нь үйл явдлууд оюуны хэмээн дүрсэлсэн үед л оюуных байдаг. Шалтгаалын номологийн онцлог шинжийн зарчмыг болгоомжтойгоор унших ёстой: энэ нь үйл явдлууд шалгаан, үр дагавар болж холбогдсон үедээ хуулийн жишээ болох дүрслэлтэй байдаг хэмээдэг. Энэ нь шалтгаалын талаарх ганц тооны үнэн бодомж бүр хуулийн жишээ болдог гэдэггүй.¹¹

II

Физикгэдгийн дунд эзлэх оюуныгэдгийн орон зай болон өгүүлбэр зүйн (syntax) ертөнцийн орон зай дунд байх утга зүйн (semantics) орон зай хоёрын дундах аналогийг хэтрүүлэн үзэж таарахгүй. Тарски тогтмол хэл (тодорхой үүднээс натуралаар авч үзэж буй үед) өөрөө өөрийнхөө хэл доторх бүх бас зөвхөн үнэн өгүүлбэрүүдийн хувьд үнэн байх 'Fx' хэмээх нээлттэй өгүүлбэрийг агуулах боломжгүй тухайд нотолсон. Хэрэв манай авч үзэж байгаа аналогийг шахвал бүх бас зөвхөн оюуны шинж бүхий үйл

11 Адилсын орлуулагдах шинж нь тайлбарын хам нөхцөл дор биелэхгүй гэх санааг Норман Малколм энд авч үзэж буй сэдвийн хамтаар 'Scientific Materialism and the Identity Theory', 123-4-д дэвшүүлжээ. Энэ номын 1 ба 8-р эсээг мөн үзнэ үү.

явдлуудын тухайд үнэн байх 'Рх' гэх физик шинжийн талаарх нээлттэй өгүүлбэр байх аргагүй гэдгийн нотолгоо бий хэмээн хүлээх болно. Гэвч, үнэн хэрэгтээ, оюуны гэдгийг цомхотгох аргагүй гэдэг талаар хэлэх зүйлсийнхээ алийг ч би нотолгоо хэмээвэл зохино гэж хэлж чадахгүй; бас ийм төрлийн үл цомхотгогдох чанар нь өөр юм. Учир нь хэв бус тохиолдлын монизм зөв бол, оюуны үйл явдал бүрийг тус тусад нь дан ганц физик ойлголтуудаар ялган хэлэх боломжтойгоор үл зогсон, бидний мэдэж байгаа хэмжээнд, оюуны предикат бүрийн дор байх үйл явдлын тоо нь төгсгөлтэй байж болох учраас оюуны предикат бүртэй ижил багтаамж бүхий физик нээлттэй өгүүлбэр байж болно, гэсэн ч ийм өгүүлбэрийг байгуулах явцад урт бөгөөд шинэ мэдлэг өгдөггүй сэлгээ бүхий уйтгарт явдал хамаарч болох юм. Хязгаартай гэж үзээгүй байлаа ч, нэг нь оюуны нөгөө нь физик байх нэгэн ижил багтаамж бүхий предикатууд байх боломжтой гэдгийг үгүйсгэх үл дийлдэх учир шалтгаан байхгүй мэт харагдаж байгаа нь үнэн.

Сэдэв маань илүүтэйгээр оюуны гэдэг нь номологийн үүднээс үл цомхотгогдох шинжтэй тухайд юм: оюуны бас физик хоёрыг холбох үнэн ерөнхийллийн бодомжууд буюу хуулийн логик хэлбэр бүхий бодомжууд байж болно; гэхдээ тэдгээр нь хууль шиг (дүрслэх учиртай хатуу утгаар) биш юм. Хэрэв схотастик бус, үнэн, сэтгэц-физикийн ерөнхийлөлд хөгийн гэмээр өчүүхэн боломжоор бүдрэх байсан бол бидэнд үүнийг барагцаа төдий үнэнээс давна гэдэгт итгэх ямар ч учир шалтгаан байхгүй байх байсан.

Сэтгэц-физикийн (чанд) хууль байхгүй хэмээн тунхагласнаараа бид шинжлэх ухааны эмпирик нөөшинд халдсан хэрэг—философичдод сэрэмжлүүлдэг нэг төрөл омог (hubris)— болох уу? Мэдээж хэрэг, аливаа бодомжийг хууль шиг эсвэл хууль бус хэмээн шүүн дүгнэнэ гэдэг бол түүний

үнэн эсэхийг даруй шийднэ гэсэн үг биш; тохиолдуудад тулгуурлаад, ерөнхийлсөн бодомжийн хүлээн зөвшөөрөгдөх байдлаас харьцангуйгаар, үүнийг хууль шиг ёсчлох нь а priori байх ёстой. Гэхдээ тийм харьцангуй а приоризм өөрөө бол философийг зөвтгөхгүй, учир нь аливаа бодомжийн тохиолдлуудад тулгуурлан түүнд итгэхээр шийдэх үндэс нь өөрөө эргээд, ерөнхийдөө, шинжлэх ухааныхаас ялгагдахааргүй онолын бас эмпирик ач холбогдлын захиргаан дор байдаг. Хэрэв энд авч үзэж буй оюуны хийгээд физик үйл явдлуудыг холбосон хуулиуд өөр бол, энэ нь тийм хуулиуд байх боломжийг зөвшөөрнө гэдэг бол сэдвээ өөрчилснөөс өөрцгүй болж байгаагаас болоод тийм байх болно. Сэдвээ өөрчилнө гэдгээр би ийм утгыг илтгэж байна: хэллэгэн хандлагын үгсийн сангийн хувьд оюуны гэдгийн шалгуурыг хүлээн авахгүй байхаар шийдэх. Гэхдээ энэ богинохон хариулт уг асуудал цааш салаалах явдлаас сэргийлж дөнгөхгүй, учир нь сэдвээ солих хийгээд хуучин сэдвийн талаар юу хэлэхээ солих буюу ядаж энд авч үзэж буй хам сэдвийн хүрээнд, философи ба шинжлэх ухааны хооронд илэрхий зааг байхгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх явдал хоёрын дунд илэрхий зааг байхгүй юм. Төвшитгөсөн хил хязгаар үгүй юм бол хэзээ ч зөрчиж болохгүй, тогтворгүй зааг л гэж байна.

Тодорхойлолтын бехавиоризмийн (definitional behaviourism) бүтэлгүйтэл хэмээх дээрхтэй холбоотой өөр нэг асуудлыг авч үзвэл оюуны-физикийн ерөнхийллийн аналогийн онцлог шинжийн ач холбогдол тодорч ирнэ. Бид яагаад оюуны ойлголтын тухайд авир үйлийн (behaviours) ойлголтуудын үүднээс илэрхийгээр тодорхойлох оролдлогоо орхих гэдэг вэ (би өөрсдийгөө тэгдэг хэмээн үзэж байгаа). Бүх бодитой оролдлого хангалттай сайн биш гэдгээс л зөвхөн болдоггүй нь мэдээж. Харин өөр олон төрөл бүхий тодорхойлолтын

редукционизмын тохиолдлууд дээр (ёс зүйн талбар дахь натурализм, шинжлэх ухааны талбар дахь инструментализм хийгээд операционализм, утгын талаарх шалтгаацлын онол, феноменализм гэх мэт өөр бусад — философиин ялагдлын каталоги) гардагтай ижлээр бүтэлгүйдэлд тогтолцоо байдаг гэх ятгалгад ордог учраас гэвэл илүү зохино. Ямар ч оюуны ойлголт хэрэглэлгүйгээр аливаа хүн Ангараг дээр амьдрал бий хэмээн итгэнэ гэдэг нь юу гэсэн үг болох тухай хэлэх гэж оролдож байна гээд үзье. Ийн үзэж болох юм: тухайн хүн дэргэд байснаар тодорхой дуу чимээ ('Ангараг дээр амьдрал бий юу?') гарах үед мөнөөх хүн өөр нэг дуу чимээ ('Тийм') гаргасан. Гэхдээ тэр хүн Англи хэлээр ойлгодог үед л уг хүн Ангараг дээр амьдрал байдагт итгэдгийг, чимээ гаргасан нь сэдэмжтэй байсныг, бас Англи хэл дээр ямар нэг утга илэрхийлж буй дуу чимээнд хариу өгч байсан гэдгийг; бас өөр олон зүйлсийг харуулна. Дутуу байгааг нь нээн илрүүлсэн зүйлс болгоны тоогоор бид шинэ нөхцөл нэмж оруулдаг. Гэхдээ яаж ч нөхөж, оюуны-бус нөхцөлүүдийг тааруулж оруулсан ч гэлээ оюуны хэмээх шинжид орох нэмэлт нэг нөхцөл хэрэгтэй болж байгааг ямагт олж харна (тухайн хүн анзаарсан, ойлгосон гэж үзээд).¹²

Тодорхойлолтын цомхотголын оролдлогууд дээр байдаг нэг гайхмаар шинж бол тодорхойлогч (definiens) хийгээд тодорхойлогдогч (definiendum) хоёрын дундах ойролцоо утгын асуудлаас тун өчүүхэн хамааралтай мэт харагддаг нь юм. Бид сөргүүлсэн жишээнүүдийг (counterexamples) төсөөлснөөр ойролцоо утгын талаарх баталгаануудыг үл тоомсорлож байгаа нь мэдээж. Гэхдээ бүтэлгүйтлийн хэв загвар нь илүү хүчтэй нэг дүгнэлтийг сануулна: хэрэв Авир үйл заасан нэр томъёонуудаар илэрхийлэгдэх, бас ямар нэг оюуны предикаттай яг ижил

багтаамж бүхий нээлттэй өгүүлбэр олно гэвэл үүнийгээ олчихлоо гэдэгт биднийг учир шалтгаантайгаар үнэмшүүлж чадах зүйл үгүй. Бид бодол, авир үйл хоёрын тухайд энэ хоёрыг холбох яв цав бас даяар түгээмэл бодомжууд байдаг гэдэгт итгэхүйц тийм их зүйл мэддэг. Итгэл үнэмшил, хүсэл эрмэлзэл нь хил хязгааргүй өөр олон итгэл үнэмшил, хүсэл эрмэлзэл, хандлага хийгээд хандахуйгаар дамжиж бас өөрчлөгдсөн байдлаар л авир үйлд гарч ирдэг. Оюуны хэмээх талбарын энэ холизм яах аргагүй оюуны гэдгийн автономи бас хэв бус тохиолдолт шинжийн аль алийнх нь талаарх учиг мөн. Эдгээр тайлбарууд зохистой хэлбэр бүхий тодорхойлолтын бехавиоризм хамгийн сайндаа оюуны хийгээд физикийн хоёрын дунд номологийн холбоос бий гэж хүлээх хэрэггүй тухайд л битүү дохио өгнө гэдгийг харуулж байна. Гол хэрэг нь бол дахиад өөр зүйлсийг бодолцож үзэхийг шаардана.

Хууль төст бодомжууд бол баримтаас-зөрсөн (counter-factual) бас болзох төлөв бүхий (subjunctive) баталгаануудыг дэмждэг, бас тэдгээрийн жишээг түшдэг ерөнхийллийн бодомжууд мөн. Хууль төст гэдгийн талраах асуулт-гуйдаггүй (non-question-begging) тийм шалгуур үгүй (миний үзэж байгаагаар бол). Энэ нь тухайлсан тохиолдлуудад шийдэмж (judgment) гаргах учир шалтгаан үгүй хэмээж буй хэрэг хараахан биш. Хууль төст чанар бол зэргээс хамаарах асуудал бөгөөд энэ нь авч хэлэлцэж байгаа тэр хүрээнээс давсан тохиолдлууд байх бололцоог үгүйсгэдэггүй. Бас харилцааны нөхцөлүүдээр тавьсан хязгаар дотор бодомжуудын хэв загварт буй нэгж юмсын хооронд өөр өөр зэрэг бүхий номологи чанар тохогдохуйц маш их ялгаа багтах зай бий. Энэ бүх талаар үзвэл номологи чанар (nomologicality) нь аналитик чанартай маш төстэй бөгөөд аль аль нь утгатай холбоотой учраас үүнд гайхах зүйл үгүй.

¹² Үүнийг Родерик Чизхолм *Perceiving, Ch. 2-тоо боловсруулсан.*

‘Бүх маргад ногоон өнгөтэй байдаг’ гэдгийг тохиолдлууд нь баталгаажуулдаг учраас энэ нь хууль төст юм. Гэхдээ ‘бүх маргад цэнхэр ногоон (grue) өнгөтэй’ гэдэг бол тийм биш. Учир нь ‘цэнхэр ногоон’ гэдэг нь ‘ t хугацаанаас өмнө харвал ногоон, нөгөө бол цэнхэр гэсэн үг бөгөөд бидний ажиглалт бүгдээрээ t хугацаанаас өмнө болж нэгэн ижил ногоон маргадыг харуулсан бол энэ нь бусад маргадуудыг цэнхэр өнгөтэй байна хэмээн үзэх учир шалтгаан болохгүй. Энэ нь зарим предикат, жишээ нь ‘цэнхэр ногоон’ гэдэг нь хуульд тохирохгүй тухайд санаа дэвшүүлжээ (тэгэхээр бас тохиромжтой предикатуудын шалгуур нь хууль төст байдлын шалгуур өөд нүүж болно). Гэхдээ надад бол ‘Бүх маргад цэнхэр ногоон өнгөтэй’ гэдгийн хэв бус байдал нь ‘бол маргад’, ‘цэнхэр ногоон өнгөтэй’ гэсэн предикатууд нэг нэгдээ тохирохгүй гэдгийг л харуулж байгаа: цэнхэр ногоон өнгөтэй байдал бол маргадуудад байх индуктив шинж биш. Харин энэ бол өөр төрлийн юмсын, жишээ нь, эмеририйн идуктив шинж мөн. (Хэрэв аливаа зүйл t хугацаанаас өмнө шалгуулсан бас маргад бол тэр эмерир болно, хэрэв үгүй бол биндэрьяа болно ‘Бүх маргад ногоон өнгөтэй’ ба ‘Бүх биндэрьяа цэнхэр өнгөтэй’ гэдэг хууль төст бодомжуудын конъюнкцаас ‘Бүх эмерир цэнхэр ногоон өнгөтэй’ гэдэг нь урган гарахаас гадна, лав л миний харж байгаа хэмжээнд, үүнийг өөрийг нь хууль төст гэх интуицийн ангижралаас татгалзах учир шалтгаан алга. Номологийн бодомжууд бидний а priori байдлаар мэддэг тэр бодомжууд нэг нэгдээ тохирно гэдгийг тодорхой болгодог — өөрөөр хэлбэл, тэдний дунд холбоос байгааг нотолгоо дэмжиж байгаа эсэхийг мэдэхээс тусдаа байдлаар мэдэх. ‘Цэнхэр’, ‘улаан’, бас ‘ногоон’ зэрэг өнгө маргад, биндэрьяа болон сарнайнд таарна; ‘цэнхэр ногоон’, ‘ногоон цэнхэр’ болон ‘ногоон улаан’ өнгө нь биндэрьеэ, эмерир, масарнайнд таарна.

Яриа дараах чиглэлд хөдөлсөн харагдаж байна: оюуны хийгээд физик предикатууд нэг нэгдээ таарахгүй. Хууль төсөөт байдлын хувьд, сэтгэц-физикийн бодомжууд болбоос “Бүх маргад ногоон байдаг” гэдгээс илүү “Бүх маргад цэнхэр ногоон” гэдэгтэй төстэй байна.

Энэ батлан мэдэгдэж буй зүйл үнэмшилтэй санагдахаас урьдаар үүнд нэн чухал засвар оруулах ёстой. Ямар нэг t хугацаанаас өмнө шинжилж үзсэн маргадууд цэнхэр ногоон байсан гэх баримт нь бүх маргад цэнхэр ногоон өнгөтэй байдаг гэдэгт итгэх учир шалтгаан биш болоод зогсохгүй; энэ ерөөс ажиглалтад ороогүй ямар нэг маргад цэнхэр ногоон өнгөтэй гэдэгт итгэх учир шалтгаан ч биш (хэрэв бид хугацааг нь мэдэж байгаа бол). Гэхдээ оюуны төрөлд хамаарах тодорхой үйл явдал ихэвчлэн физик төрөлд хамаарах аливаа үйл явдалтай хамсаж байдаг бол, энэ нь бусад тохиолдлууд дээрхтэй ойролцоо харьцаагаар ижил байна хэмээн үзэх сайн учир шалтгаан болох нь олон. Тийм практик мэргэн ухааныг цогцлоож буй ерөнхийллүүдийг багцаагаар л үнэн байна гэж үздэг, эсвэл эдгээрийг магадлалын нэр томъёогоор тодорхой мэдэгддэг, нэг бол хариуцлагаас чөлөөлөх гэрээний заалтуудаар, өгөөмрөөр, сөргүүлсэн баримтуудаас салгадаг. Эдгээрийн гол ач холбогдол ганц тоон дээрх шалтгаацлын баталсан мэдэгдэл хийгээд үүнд холбогдох тухайлсан үйл явдлын тайлбаруудыг зээлж дэмжлэг болдогт нь бий. Дээрх шиг ерөнхийлөл хэдий болхи хийгээд бүдэг боловч тодорхой тохиолдлын цаана тодоор бас ямар нэг болгоомжлолгүйгээр томъёолж болохуйц нэгэн жигд байдал (regularity) бий гэдэгт итгэх сайн учир шалтгааныг өгч болох юм.

Өдөр тутамд урьдаас харж бас ойлгох ёстой болдог үйл явдал хийгээд үйлдлүүдийн урсгал дунд бид аргагүйн эрхэнд барагцаалж, тоймлосон ерөнхийллийг

ашигладаг. Учир нь бид түүнээс илүү оновчтой хуулийг мэддэггүй, мэддэг байлаа ч мөнөөх хуульд холбогдолтой зүйлсийг харуулах бидний сонирхож буй тухайлсан үйл явдлуудын дүрслэл бидэнд байхгүй. Бүдүүнээр барагцаалсан дүрэм (rude rule of thumb) хэмээх категори дотор гаргах өөр нэг чухал зааг бий. Нэг талаас, аливаа эерэг тохиолдлууд нь бидэнд тухайн эх ерөнхийллийнхтэй ижил ерөнхий үгсийн сан дотор батлан мэдэгдэж болохуйц болзол, нөхцлүүдийг нэмснээр уг ерөнхийллийг өөрийг нь хөгжүүлж болно гэдэгт итгэх учир шалгаан өгдөг тийм ерөнхийлүүд бий. Тийм ерөнхийлүүд гүйцэд төгс болсон хуулийн үгсийн сан ба хэлбэр өөд заадаг: үүнийг бид хомономик ерөнхийлөл хэмээж болох юм. Нөгөө талд, тохиох үедээ бидэнд хүчинтэй буй чанд хууль байна гэдэгт итгэх учир шалтгаан өгч болох ч өөр үгсийн сан руу шилжиж байж л батлан мэдэгдэх боломжтой тийм ерөнхийлүүд бий. Тийм ерөнхийлүүдийг гетерономик гэж болно.

Бидэнд уламжилж ирсэн практик мэдлэгийн (бас шинжлэх ухааны) дийлэнх нь гетерономик юм. Энэ нь аливаа хууль ойлголтуудаа иж бүрэн, хаалттай онолоос авч байгаа бол тэр хуулийг аль болох чанд, нарийн тодорхой бөгөөд онцгой тохиолдолд өртдөггүй хэмээн найдаж болдогтой холбоотой. Энэ идеал онол нь детерминист шинжтэй эсвэл үгүй байж болно. Гэхдээ ямар ч үнэн онол детерминист шинжтэй байдаг бол уг онол детерминист байж таарна. Физик юмсын шинжлэх ухаанаас хомономик ерөнхийлөл олдоно, хэрэв тийм ерөнхийлүүд нотолгоогоор дэмжигдэж байвал, нэмэлт физик ойлголтуудыг ашиглаад эдгээрийг тодорхойгүй хэмжээгээр улам тодруулж болно хэмээн итгэх учир байна: Бүх л нотолгоо, төгс урьдчилан таамаглагдах байдал (тогтолцооны нөхцөлүүд дор), бүрэн тайлбартай (мөн л тогтолцооны нөхцөлүүд

дор) төгс уялдах байдлын асимптот бий. Эсвэл, эцсийн онол нь (ultimate theory) магадлалын шинжтэй бөгөөд асимптот нь төгсөөс наагуур байж болох; гэхдээ тэгвэл түүнээс илүүг олж авах боломж үгүй байна.

Аливаа бодомжийг хомономик, өөрөө өөрийнхөө ойлголтын хүрээ дотор засвар авах боломжтой гэдэгт итгэлтэй байхад уг бодомж нь ойлголтуудаа хүчтэй тулгуур элемент бүхий онолоос авсан байх шаардлагатай. Байж болох хамгийн энгийн зураглал ийм байна; хэрэв хичээлийг ойлгосон бол энгийнжүүлэлтийг засаж болно гэдэг нь илэрхий байх учиртай.

Урт, жин, температур эсвэл цагийн (өөр олон зүйл байгаа нь мэдээж) хэмжил зүй нь транзитив бөгөөд тэгш хэмтэй биш байх хоёрлосон харилцааны тохиолдол бүрийн оршихуйгаас хамаарч байдаг: илүү дулаан, сүүлд нь, илүү хүнд гэх мэт. Илүү урт гэдгийг жишээ болгон үзье. Транзитив чанарын хууль эсвэл урьдчилсан нөхцөл (postulate) ийм юм:

$$(L) L(x, y) \text{ ба } L(y, z) \rightarrow L(x, z)$$

Энэ хууль (эсвэл ямар нэг боловсронгуй хувилбар нь) хүчинтэй биш л бол бид уртын талаарх ойлголтыг утгат чанартай болгож хялбар дөнгөхгүй. Ратио хэмжээсийн илүү хүчтэй шаардлагыг үл тооцоод, аливаа бүртгэлд, уртын эрэмбэд хүртэл ямар ч тоог хамаатуулах аргагүй. Бас энэ тайлбар интранзитив байдалтай шууд холбогдох дурын гурван нэгжид л хамаараад зогсохгүй: (L) нь бүрэн ерөнхийлөлд хүчинтэй биш л бол ямар ч нэгжид тогтвортой хамаатуулах зэрэглэл үгүй гэдгийг хялбархан харуулж болно (уртыг хэмжихэд зайлшгүй шаардлагатай цөөн хэдэн зүйлийг нэмж тооцоод).

(L) дангаараа 'илүү урт' гэдгийн импортыг шавхаж чадахгүй нь илэрхий — тийм биш байсан бол энэ нь 'илүү дулаан' эсвэл 'хожим' гэдгээс ялгарахгүй байсан. Бид хэрэглэх боломжтой байгаа үгсийн сангаараа томъёолоход хэдий хүнд боловч

‘илүү урт’ гэдгийг хэмжил зүйн бусад хоёр оронт транзитив предикатаас (two-place predicate) ялгаж бас нэг зүйл нөгөөгөөс урт хэмээн батлан хэлэх суурь болох тийм эмпирик агуулга бий хэмээн үзэх ёстой. Энэ эмпирик агуулгын хэсэг нь ‘ $O(x, y)$ ’ гэх предикатаас гарна гэж төсөөлье. Тэгвэл бидэнд дараах ‘утгын постулат’ гарч ирнэ:

$$(M) O(x, y) \rightarrow L(x, y)$$

Энэ нь (L)-ийн хэсэгчилсэн тайлал болно. Гэхдээ одоо бол (L), (M) хамтдаа тун хүчирхэг эмпирик онолыг агсаж байна. Учир нь эдгээрээс $O(a, b)$, $O(b, c)$, $O(c, a)$ байх a, b, c гурван объект оршдоггүй гэх мөрдлөгөө гарна. Гэсэн ч ‘ $O(x, y)$ ’ гэдэг нь ямагт итгэлтэйгээр тавьж болох предикат бол тийм зүйл болохоос юу сэргийлж болох вэ? Өөрсдийгөө интранзитив гурвалыг ажигласан хэмээн бодож байна гэж үзье; тэгвэл бид юу гэж хэлэх вэ? Бид (L)-ийг худал хэмээн тооцож болно, гэхдээ тэгвэл урт хэмээх ойлголтыг яаж ч хэрэглэх аргагүй болно. Бид (M) нь уртын буруу тест өгнө хэмээж болох; гэхдээ тэгвэл нэг зүйл нөгөөгөөс урт байх тухай санааны агуулгыг юу гэж бодож байсан маань тодорхой бус болно. Эсвэл бид ажиглалт дор буй объектууд нь, онолын шаардлага дагуу, чанд (rigid) объектууд биш гэж болох. Бид эдгээр хариултуудын аль нэгийг хүлээн авахаас аргагүй гэж үзэх нь алдаа болно. Урт гэдэг шиг ойлголтууд хэд хэдэн концептуал шахалт дор тэнцвэрээ хадгалж байдаг, бас бид дээрх хариултуудыг шахвал тулгуур хэмжүүрийн онолууд гажуудах бөгөөд үүнд (L), (M) зарчмууд ч багтана: аналитик эсвэл синтетик. Уртын хэмжүүрийн аксеомууд, хуулиуд эсвэл постулатуудын бүхэл олонлог нь энгийн нүдээр харж болох, чанд, физик объектуудын тогтолцооны талаарх санааны хэсгийг бүрдүүлдэг гэх нь илүү дээр юм. Физикийн шинжлэх ухааны хууль төст бодомжуудын оршихуй нь ижилхэн концептуал хүрээнд буй уртын хэмжүүр гэдэгтэй төстэй үндсэн (синтетик а priori) хуулийн оршихуйгаас хамааралтай байна.

Аливаа нэг төрөл бүхий объектуудад хүчинтэй байх цогц (comprehensive) онол байхгүй бол бид ямар ч объектод ухварлагдахуйц байдлаар (intelligibly) уртыг хамаатуулж болдоггүйтэй адилаар, итгэл үнэмшил, хүсэл эрмэлзэл, сэдэмж, шийдвэрүүдийнх нь талаарх амьдрах чадвартай онолын ерөнхий бүдүүвч дотор л биш бол хэллэгэн хандлагыг (propositional attitude) үйл эрхлэгчид ухварлагдахуйц байдлаар хамаатуулж чадахгүй.

Хэлэхүйн үйлдэл, сонголт эсвэл өөр бусад байршлын дохио (local sign) хэчнээн ил бөгөөд тодорхой байсан ч, эдгээр дээр тулгуурлаад аливаа хүнд итгэл үнэмшлүүдийг нэг нэгээр нь хамаатуулах аргагүй. Учир нь бид тухайлсан итгэл үнэмшлүүдийг бусад итгэл үнэмшил, шилэн сонголт, сэдэмж, найдвар, айдас, хүлээлт болон үлдсэн бусад юмстай уялдуулах байдлаар л утгат чанартай болгодог. Энэ нь уртын хэмжүүртэй ижлээр, зүгээр л, тохиолдол бүр нь онолыг шалгаж бас түүнээс хараат байдаг биш, харин хэллэгэн хандлаын агуулга нь хэв загварт эзлэх түүний байраас гарч ирдэг.

Хүмүүсийг өндөр зэргийн тогтвортой байдалтай гэж тооцох явдлыг зүгээр л элбэрэл (charity) хэмээн үзэж болохгүй: хэрэв бид тухайн хүмүүсийг алдаа хийгээд тодорхой зэргийн иррационал байдлын төлөө утга төгөлдөрөөр буруутгах байр сууринд байсан бол дээрхээс зайлах аргагүй байна. Төсөөлөл тээнэгэлзүүлснээс болоод биш, харин хэт их эргэлзээ нь ганцаар алдааны тайлбар болж чадах тэрхүү үнэн итгэл үнэмшлийн дэвсгэрийг элээх үлэмж алдааны тухайд эргэлзэх зүйл үлдээдэггүй болохоор түгээмэл алдаа гэдэгтэй ижлээр, түгээмэл эргэлзээ гэдгийн тухайд би ухан ойлгож чадашгүй юм. Бид бусдад хамаатуулж болох эндүүрэл хийгээд алдаатай муу бодохуйн зэрэг, төрөлд хамаарах тийм зөв ойлгож ухаарах явдал бол аливаа бие хүн (person) ямар

ойлголтуудыг захирч байгаа талаарх асуулт болон тэр хүн итгэл үнэмшил, хүсэл эрмэлзэл, сэдэмждээ мөнөөх ойлголтуудыг хэрхэн ашиглаж буй талаарх асуулт хоёрыг хооронд нь салгажгүй тэр шинжийг дахин авч үзнэ гэсэн үг юм. Бид бусдын хандлага хийгээд үйлдлийн дундаас авцалдаатай бөгөөд үнэмшилтэй хэв загварыг нээн илрүүлж чадахгүй байх тусам тэднийг бие хүн хэмээн хандах боломжоо тэр чинээгээр хаяж буй хэрэг болно.

Ил тодорхой хэлэхүйн авир үйлд хандсанаар асуудлыг тойрохгүй, харин ч үүнийг төвд авчирч тавина. Учир нь аливаа хүн хэрэглэж буй өгүүлбэрүүдээ баримталж, мөрөөсөж байгаа нэг бол тэдгээрийг үнэн байлгахыг хүсэж байгаа гэх мэтээр өгүүлбэрүүддээ хэрхэн хандаж байгааг ойлгож чадахгүй бол тэр хүний хэлж буй зүйлсийг тайлж ойлгож чадахгүй. Ийм хандлагуудаас эхлээд цааш тэр хүн ямар утга илэрхийлж байгаа талаарх онолыг боловсруулах ёстой. Тэгснээр түүний хандлага бас үгст нэгэн зэрэг агуулга оноож байгаа хэрэг. Мөнөөх хүний үгсийг утгат чанартай болгох хэрэгцээнийхээ үүднээс бид түүнийг дотооддоо зөрчилгүй (consistent), үнэн юмсад итгэгч, сайныг хайрлагч болгон үздэг онолыг оролдож үзнэ (мэдээж өөрсдийнхөө үнэмшлээр гэдгийг хэлэх шаардлагагүй). Амьдрал байдгаараа л байна, дээрх шаардлагыг бүрэн хангах энгийн онол гарч ирэхгүй. Олон онол их бага хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдөхүйц зөвшилцөлд хүргэнэ, харин энэ онолуудын дундаас сонголт хийх обьектив суурь үгүй байж болно.

Оюуны хийгээд физикийн мөрүүдийг холбож буй ерөнхийллийн бодомжуудын гетерономик шинж нь бүх хэллэгэн хандлагын (propositional attitude) дүрслэлдэх орчуулгын гол үүрэг хийгээд

орчуулгын тодорхойгүй байдлаас (indeterminacy of translation) улбаатай.¹³ Оюуны хийгээд физикийн схемүүдийн хооронд нь харьцуулшгүй *commitment*-ээс болоод сэтгэц-физикийн чанд хууль байдаггүй. Аливаа физик өөрчлөлтийг физик байдлаар дүрслэгдэх бусад өөрчлөлтүүд хийгээд нөхцөлүүдтэй холбох хуулиудаар физик өөрчлөлтийг тайлбарлаж болдог нь физик бодит байдлын нэг шинж мөн. Оюуны үзэгдлийг хамаатуулах явдал нь хувь хүнд буй учир шалтгаан, итгэл үнэмшил ба сэдэмжийн суурь болох ёстой гэдэг нь оюуны гэдгийн шинж мөн. Хэрэв дээрх хоёрын аль аль нь өөр өөрсдөдөө зохих нотолгооны эх сурвалжийг хадгалж үлдэнэ гэвэл уг хоёр талбарын дунд чанга холбоос байх арга үгүй. Оюуны гэдгийн номологийн үл цомхотгогдох шинж нь бодол, илүүд үзэх явдал хийгээд сэдэмжийн ертөнцийн ямар ч завсаргүй уг чанараас л урган гардаг юм биш. Учир нь тийм тусгаар байдал физикийн онолд нийтлэг байх бөгөөд орчуулгын схемд релативчлалгүйгээр аливаа хүний хандлагыг тайлж ойлгох цор ганц зөв арга зам бий гэх үзэлтэй тохирдог. Нэг бол зүгээр л нэг нэгтээгээ ижил тэнцүү таарах олон схем орших боломжоос болоод үл цомхотгогдох байдал гарч ирдэг юм биш. Учир нь энэ нь оюуны чанаруудыг хамаатуулж буй схемийн дурын сонголттой нийцтэй байна. Гол нь бид итгэл үнэмшил, хүсэл эрмэлзэл болон бусад ойлголтуудын тухай ярихдаа нотолгоо арвижихын хэрээр онолоо ерөнхий итгэлцүүрийн гэрэлд нийцүүлж, засварлахад бэлэн байх ёстой: рационал байдлын хамгийн гол зорилго нь хувьсаж буй онол юу болох вэ гэдэгт хамаарах хувьслын үе шат бүрийг зарим талаар хянаж байдаг. Орчуулгын схемийн дурын сонголт нь онолыг тэгж завшаан алдалгүйгээр сайжруулах явдалд саад

¹³ *Word and Object* -ын хоёрдугаар бүлэгтээ В.В. Фуайны дэвшүүлсэн орчуулгын тодорхойгүй байдлын тухай номлолоос нөлөө авсан минь илэрхий харагдана гэж найдаж байна. 45-р хэсэгтээ Куайн орчуулга ба хэллэгэн хандлагын хооронд холбоос татаж интенционал хэлцийн үл цомхотгогдох байдлын тухай Брентаногийн сэдвийг орчуулгын тодорхойгүй байдлын тухай сэдэвтэй нийцтэйг онцолсон, 221.

хийнэ; өөрөөр хэлэх юм бол, орчуулгын гарын авлагын зөв дурын сонголт нь бололцоот бүх нотолгооны үүднээс хүлээн зөвшөөрөгдөхүйц байх бөгөөд бид ийм сонголт хийж чадахгүй. Бид хүнийг рационал амьтан хэмээн үзэж байгаа бол оюуны хийгээд физик гэдгийн хоорондох номологийн хүлхгэр зайг хүлээн зөвшөөрөх нь зайлшгүй хэмээн дүгнэх учиртай гэж би бодож байна.

III

Энд өрнөж буй ярианы гол санаа нь, бас дүгнэлт нь бидэнд танил зүйл байх болно. Оюуны хийгээд физикийн гэдгийн дунд категорын ялгаа байдаг гэдгийг бүгд мэднэ. Оюуны гэдэгт хамаатуулах учиртай хувийн шинж, эсвэл үйл эрхлэгч хэллэгийн хандлагынхаа дээр байх өвөрмөц эрх дархын тухайд юу ч хэлээгүй нь хачирхалтай санагдаж болох ч гэлээ аливаа орчуулгын схемийг хүлээн зөвшөөрөх суурийн талаар илүү нарийн авч үзсэн бол энэхүү шинэлэг мэт үзэгдэх байдал замхран үгүй болох байсан. Оюуны хийгээд физикийн гэдгийн дундах категорын ялгаанаас тэдгээрийн дунд орших чанд хууль орших боломжгүй гэдэг рүү нэг алхам хийх явдал цоо шинэ биш боловч тийм ч нийтлэг биш. Хэрэв гайхмаар зүйл гарвал, тэр нь, хууль төст гэдгийн парадигм буюу физик гэдгийн хийгээд оюуны гэдгийн дундах адилслыг тогтооход үйлчилж буй оюуны гэдгийн хуульгүй байдлыг олох явдал мөн.

Учир шалтгаан нь дараах юм. Бид Оюуны гэдгийн Шалтгаан бүхий Хамааралт байдлын зарчим (Principle of the Causal Dependence of the Mental) дор бол зарим оюуны үйл явдал нь ядаж зарим талаар физик үйл явдлуудын шалтгаан эсвэл үр дүн байдаг гэж үзэж байгаа. Хоёр дахь нь ганц тоон дээрх шалтгаан заасан үнэн бодомж бүр шалгаан ба үр дагавар гэгдэж буй үйл явдлуудыг холбосон чанд хууль дээр тулж байдаг гэх (Шалтгаанцлын Ноломлогийн Шинжийн) зарчим юм. Бүдүүн болхи боловч хомономик хуулиуд байгаа цагт ижил ойлголтын

хүрэнээс гарч ирэх хуулиуд байх бөгөөд үүнийг илүү цогц бас нарийн оновчтой болгох тухайд ямар ч ахиц гарахгүй. Бид өмнөх хэсэгт тийм хуулиуд физикийн шинжлэх ухаануудад тохиолддог хэмээх санааг хүчтэй дэвшүүлсэн. Физикийн онол нь бидэнд хууль төст гэдгийг дагах үгсийн сангаар илэрхийлэгдэх физик үйл явдал бүрийн талаарх жишиг тогтсон, онцгой дүрслэлийг баталгаатай гаргаж өгөх цогц бөгөөд хаалттай тогтолцоог өгнө хэмээн амладаг.

Зүгээр л, оюуны гэдэг нь дээрх нэгдүгээр зарчмын дагуу хаалттай тогтолцоог бий болгодоггүй учраас оюуны гэгдэх ойлголтууд дангаараа тийм ерөнхий бүдүүвчийг гаргаж чадна хэмээн итгэхэд бэрх. Оюуны гэдгийн тогтолцоот хэсэг биш боловч оюуны гэдэгт нөлөөлөх дэндүү олон үйл бий. Гэвч бид энэ ажиглалтыг ямар ч сэтгэц-физикийн бодомж чанд хууль болдоггүй бөгөөд болох боломжгүй хэмээх дүгнэлттэй нийлүүлбэл Оюуны гэдгийн Хэв бус тохиолдолт шинжийн Зарчмыг олно: оюуны үзэгдлийг урьдчилан таамаглаж бас тайлбар хийж чадах тэр суурин дээр ямар ч чанд хууль байх боломжгүй.

Эндээс адилслыг амархан харуулчихаж болно. m гэдгийг p гэх физик үйл явдлаар шалтгаанцсан оюуны үйл явдал гэе; бас ямар нэг дүрслэлийн дор t ба p нь чанд хуулийн жишээ болдог гэе. Өмнөх цогцолбороос үзвэл энэ хууль зөвхөн физик хууль байх боломжтой. Гэвч t физик хуульд хамаарах юм бол, үүнд физик дүрслэл байж таарна; өөрөөр хэлбэл энэ нь физик үйл явдал гэсэн үг. Физик үйл явдал нь оюуны үйл явдлаар шалтгаанцаж буй тохиолдолд ч ийм үндэслэгээ хүчинтэй байна. Иймд физик үйл явдалтай шалтгаанцлын хувьд холбоотой бүх л оюуны үйл явдал бол физик үйл явдал гэсэн үг. Хэв бус тохиолдлын монизмыг хамгийн ерөнхийгөөр үндэслэхийн тулд бүхий л оюуны үйл явдлууд ямар нэг физик үйл явдлын шалтгаан эсвэл үр дагавар болж байдгийг харуулахад л хангалттай; би

ингэхийг завдахгүй.

Хэрэв нэг үйл явдал нөгөөгийнхөө шалтгаан болдог гэвэл тэдгээрийг зохистойгоор дүрсэлсэн үед мөнөөх үйл явдлууд жишээ нь болох чанд хууль байх учиртай. Гэвч хууль эсвэл түүнд хамаарах дүрслэлүүдийг мэдэхгүйгээр ганц тоон дээрх шалтгаацлын харилцааг мэдэх боломжтой (бас энэ нь элбэг тохиодог). Мэдлэг учир шалтгаануудыг шаарддаг, харин энэ учир шалтгаанууд нь бүдүүн баараг, гетерономик ерөнхийлөл хэлбэрээр олдох боломжтой. Энэ ерөнхийллүүд нь мөнөөх жишээнүүдийн хувьд хууль төст гэдгийг тодорхой болоогүй хэмжээнд сайжруулсаар байх боломжтой гэдэг үүднээс бол өөр бусад жишээнүүд гарч ирнэ хэмээн хүлээх үндэс бий. Ийм баримтуудыг адисллын мэдлэг дээр буулгавал, чухам аль оюуны үйл явдал нь физик үйл явдал вэ гэдгийг мэдэхгүйгээр аливаа оюуны үйл явдал гэдэг нь зарим физик үйл явдалтай адил гэдгийг мэдэх боломжтой (түүнийг тодорхой нэг хууль дор оруулах өвөрмөц физик дүрслэл хийх боломжтой гэд үүднээс). Хэн нэг хүн ертөнцийн бүх физик түүхийг мэддэг байлаа ч, бас бүх оюуны үйл явдал физикийн гэдэгтэй адил байлаа ч тэр хүн нэгж оюуны үйл явдлыг урьдчилан таамаглаж эсвэл тайлбарлаж чадна гэх дүгнэлтэд хүргэхгүй (мэдээж хэрэг, өмнө дүрсэлсний дагуу).

Оюуны үйл явдлуудын физик үйл явдлуудтай холбогдох харилцааны хоёр тал нь —шалтгаацлын хараат байдал ба номологийн тусгаар байдал— тэгэхээр бодол, зорилго зэргийн материаллаг ертөнцөд нөлөөлөх байдал хийгээд хуулиас чөлөөт байдлыг нэгтгэх буюу ихэвчлэн парадокс мэт харагддаг байсан асуудлыг шийдэж байна. Бид үйл явдлуудыг хүртэхүй, санахуй, шийдвэр, үйлдэл хэмээн зураглахдаа тэдгээрийг шалтгаан ба үр дагаварын харилцаагаар дамжуулаад

физикээр тохиолдож буй зүйлсийн дунд зайлшгүй багтааж таардаг; гэхдээ мөнөөх шилжсэн утгаа солиогүй байгаа цагт энэ хэлбэр бүхий зураглал нь зарчмын хувьд физик үзэгдлүүдийг тайлбарлаж бас урьдчилан таамаглахын тулд хэрэглэж болох чанд хуулиудаас оюуны үйл явдлуудыг салгадаг.

Оюуны үйл явдлуудыг нэг анги болохынх нь хувьд физикийн шинжлэх ухаанаар тайлбарлах аргагүй; бид тодорхой адислыг мэдэж буй үед тухайлсан үйл явдлуудыг бол тийн тайлбарлаж болно. Гэвч бидний ихэвчлэн сонирхож үздэг тэр оюуны үйл явдлуудын тайлбарууд бол тэдгээр үйл явдлыг өөр бусад оюуны үйл явдал бас нөхцөлүүдтэй холбодог. Бид жишээ нь, хүний чөлөөт үйлдлийг тэр хүний хүсэл эрмэлзэл (desire), зуршил, мэдлэг болон хүртэхүйд нь хандах байдлаар тайлбарладаг. Сэдэмжит авир үйлдлийн (intentional behavior) талаарх ийм баримтлалууд нь шалтгаан (cause) ба үр дагавар, учир шалтгаан (reason) ба үйлдлийн аль алийг үйл эрхлэгч хүний зураглалд хамаарах талууд хэмээн дүрсэлснээр физик хуулийн шууд нөлөөнөөс ангид тийм ойлголтын (conceptual) хүрэн дотор ажилладаг. Иймд, оюуны гэдгийн талаарх хэв бус тохиолдлын үзэл болбоос үйлдлийг автономн шинжтэй хэмээн үзэх зайлшгүй нөхцөл мөн. Кантаас авсан удаах ишлэлээр дүгнэлтээ хийе:

Хүнийг чөлөөт гэдгийнх нь хувьд нэг утгат чанар ба харилцааны үүднээс, байгалийн хуулиудад захирагдагч болохынх нь хувьд өөр нэг утгат чанар бас харилцааны үүднээс авч үздэг нь зөрчилтэй байгааг хий хуурмаг зүйл хэмээн харуулах нь спекулатив философийн зайлшгүй асуудал мөн. . . Иймд дээрх хоёр хамтдаа аятай оршиж болно гэдгээр зогсохгүй, аль алийг нь нэг сэдвийн дор нэгтгэж үзэх ёстой гэдгийг харуурах учиртай. . . .¹⁴

¹⁴ *Op. cit.*, 76.